



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/148

Улаанбаатар хот

Газар ашиглах эрх
олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, 2020 оны 152 дугаар тогтоол, 2025 оны 120 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/77 дугаар захирамж, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны А/13 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн нээлттэй дуудлага худалдаанд оролцож ялагчаар шалгарсан 1 (Нэг) аж ахуйн нэгжид газар ашиглах эрх олгон хавсралтаар баталсугай.

2. Газар ашиглах эрх олгогдсон аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, гэрчилгээ олгон, Улсын бүртгэлд бүртгэж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Газар зохион байгуулалтын алба (Ч.Магадсайхан)-нд даалгасугай.

3. Холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлж, газрыг зориулалтын дагуу зөв зохистой ашиглахыг хавсралтад нэр заагдсан аж ахуйн нэгжид үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД